



СОЙМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№89 /302/

2022.05.06

Цаг үе, үйл явдал

НАЛАЙХ ДҮҮРЭГТ “МОНГОЛ ЦЭРЭГ-ДЭЛХИЙН ЦЭРЭГ” СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ АЖИЛ ЯВАГДЛАА



Зэвсэгт хүчний 014 дүгээр анги Монгол улсын Зэвсэгт хүчин энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний түүхт 20 жилийн ойг тохиолдуулан Монгол цэргийн түүхэн замнал, Зэвсэгт хүчин, ангийн үйл ажиллагааг ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад сурталчлан таниулах, цэрэг эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх зорилгыг дэвшүүлэн олон талт ажил арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус анги Нийслэлийн Налайх дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын ахлах, дунд ангийн 120 гаруй сурагчдад “Монгол цэрэг-Дэлхийн цэрэг” сургалт, сурталчилгааны ажлыг 2022 оны 05 дүгээр сарын 06-ны өдөр Налайх дүүргийн Соёлын ордонд зохион байгуулж явууллаа. Арга хэмжээг нээж ангийн захирагчийн орлогч,

захирагчаны удирдлагын тасгийн дарга дэд хурандаа Л.Чинзориг үг хэлж, сурагч хүүхдүүдэд “Монгол улсын Зэвсэгт хүчний “Энхийг дэмжих ажиллагааны оролцоо, ач холбогдол” сэдвээр сургалт, танилцуулгыг явуулсан юм. Мөн сурагч хүүхдүүдэд “Монгол цэрэг-энхийн үйлсэд” баримтат кино, бие бүрэлдэхүүний урлагийн хэсэгчилсэн тоглолтыг үзүүлж, энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн бүрэлдэхүүний гэрэл зургийн болон энхийг сахиулагчдын анги байгууллагадаа дурсгасан дурсгалын зүйлс, тэсэрч дэлбэрэх зүйлсийн хайгуул устгалын бүлгийн багаж хэрэгсэл, буудлагын зэвсэглэлийн болон химийн тагнуулын багаж хэрэгслийн үзэсгэлэнг дэлгэн, нормативын хичээлийг зохион байгуулж явууллаа.

Хошууч Э.ХАШЦАХИУР



400 ГАРУЙ ЧАЦАРГАНЫН МОДООР ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНОО ЧИМЛЭЭ



“Алдар” спорт хороо Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигаар зарласан “Мод тарих үндэсний өдөр”-ийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн санаачилгаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Батлан хамгаалах яамны дэд сайдын 2022 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн “Албан даалгавар хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу Батлан хамгаалах яамны харьяа, Зэвсэгт хүчний “Алдар” спорт хороонд

мод тарих өдөрлөг өнгөрсөн амралтын өдрүүдэд боллоо. Уг өдөрлөгт “Алдар” спорт хорооны офицер, ахлагч, багш дасгалжуулагч тамирчид, ажилчин албан хаагч нар нийт 400 гаруй чацарганын мод тариалаа. Цаашид “Алдар” спорт хороо нь 2022-2030 онд 4000 гаруй мод, төрөл бүрийн жимс, жимсгэнийн бутыг дотоодын нөөц бололцоогоо нэмэгдүүлэн ургуулахаар төлөвлөн ажиллаж байгаа юм.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

| | | |
|--|---|--|
| ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,273,004 /69.9%/ | ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,175,662 /66.9%/ | ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 1,040,412 32,0% 125,447 /3,9%/ |
| НИЙТ БАТЛАГДСАН 8488 +112 | ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 24 | ЭДГЭРСЭН 8343 |

| |
|---------------------------------------|
| КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД |
| Тохиолдол Нийт: 517,260,241 |
| Эдгэрсэн Нийт: 471,936,537 |
| Нас барсан Нийт: 6,276,465 |

ЦАГ АГААР

| | |
|-------------|------------|
| УЛААНБААТАР | |
| Өдөр 6 | Шөнө -6 |
| ӨМНӨД СУДАН | |
| Өдөр 35 | Шөнө 26 |

ВАЛҮТЫН ХАНШ

| ВАЛҮТ | АВАХ | ЗАРАХ |
|-------|----------|---------|
| USD | 3,105.00 | 3,115.0 |
| EUR | 3,320.0 | 3,350.0 |
| CNY | 468.00 | 471.00 |
| RUB | 41.00 | 42.00 |
| JPY | 24.00 | 24.60 |
| KRW | 2.46 | 2.49 |

ЗУРХАЙ

2022.05.09 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 7

ЗУНЫ ТЭРГҮҮН ХӨХӨГЧИН МОГОЙ САРЫН ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ХАР НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал:
Нас уртасна
Наран ургах, шингэх:
Нас уртасна
Барилдлага:
Үхэх
Шүтэн барилдлага:
Өтлөх үхэхүй
Суудал: Мод

Энэ өдөр бар, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, хишиг даллага дуудуулах, цэргийн үйл, насан бүтээл хийлгэх, хүүхэд үрчлэн авах, андгай тангараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийх, эрдэнийг гадагш өгөх, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод хойд зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал нас уртадна.

ИРГЭН ТА ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛАА ХЭРХЭН ТӨЛӨХ БЭ?

- ✓ АЙМАГ, ДҮҮРГИЙН НИЙГИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС
- ✓ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВ (Дунжигараа, Мисээл эхсээ, Драгом, Баянхошуу, Инарт 3,4 хороолол)
- ✓ БҮХ ТӨРЛИЙН ИНТЕРНЕТ БАНК
- ✓ ЭНДЭГ-ЫН ГАР УТАСНЫ EDAATGAL АППЛЕЙШН
- ✓ И-БАРИМТААР ТҮС ТҮС ТӨЛӨХ БОЛОМЖТОЙ.

ЭМД

Лавлах утас: 1800-1363

Цахим шууданд

МОД ТАРИХ ӨДӨРЛӨГӨӨР ...



Зэвсэгт хүчний 167 дугаар анги

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний бүрэлдэхүүн тэргүүлэх үүрэгтэй оролцож байгаа энэ үед Зэвсэгт хүчний 167 дугаар ангийнхан ч мөн адил орон нутагтайгаа хамтран дэмжин оролцож байна.

Өмнөговь аймгаас 5 дугаар сарын 8-ны энэ өдрийг орон нутаг даяараа "Мод тарих өдөрлөг" болгон зарлаж, Даланзадгад сумын үдэлт,

угталтын талбайд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд 300 гаруй мод, суулгацыг тарих ажилд Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн бие бүрэлдэхүүн идэвхтэй хамрагдлаа.

Тус ангийнхан "Тэрбум" үндэсний хөдөлгөөний хүрээнд байгаль орчны нөхөн сэргээлт хийх, Зэвсэгт хүчний анги байгууллагын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, сэргээн сайжруулах, ойжуулах, цэцэрлэгжүүлэх, ойн зурвас байгуулах, бие бүрэлдэхүүнийг экологийн эрүүл орчинд ажиллах, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор

төлөвлөгөө гарган ажиллаж байна. Үүний нэг ангийн байнгын байрлалыг үе шаттайгаар ногоон хотхон болгох болон шинэ төмөр зам дагуух ойжуулах ажилд тэргүүлэх үүрэгтэйгээр оролцох юм.

Мөн Монгол Улсын Засгийн газраас энэ сарын 8-ны өдрийг "Үндэсний хүмүүнлэгийн өдөр" болгон зарласантай холбогдуулан аймгийн Улаан Загалмайн хорооноос зохион байгуулсан өдөрлөгт Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчид оролцсон юм

Дэслэгч Б.БАТЗАЯА

ОРХОН АЙМАГТ ЭНХИЙГ САХИУЛАХ ҮЙЛСИЙГ СУРТАЛЧЛАХ УРАЛДААНУУДЫГ ЗАРЛААД БАЙНА

Зэвсэгт хүчний 186 дугаар анги

Орхон аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад Л.Бат-Ирээдүй зуны улирлыг дагасан хуурайшилт ихсэж, түймэр дэгдэх эрсдэл өндөр байгаатай холбогдуулан Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн бүрэлдэхүүнд "Гал түймрийн аюулгүй байдал" сэдвээр сургалт зохион байгууллаа. Энэхүү сургалтын дараа 7 хоногийн төлөвлөгөөний дагуу зарим албан тушаалтан уламжлал ёсоор цагийн үеийн асуудлаар мэдээлэл

өгч, харилцан ярилцсан юм. Цэргийн гал тогооны тогооч С.Янжинлхам хүн байх, хүн хүндээ ёс зүйтэй иргэн байх тухай сургажигт яриа өрнүүлэв. Тэрээр тэсвэр хатуужил ямар үед бат суудаг, эр зоригоо ямар үед гаргаж байх, хүнлэг энэрэнгүй байхад бүх цаг үеийг зориулах тухай ч залуу офицер, ахлагч нарт ярилаа.

Түүнчлэн Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж эхэлсний 20 жилийн ойг угтаж нэлээдгүй ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байгаа билээ. Энэ хүрээнд Орхон аймгийн Ерөнхий

боловсролын сургуулийн сурагчдын дунд "Монгол цэрэг-Энхийн үйлсэд 20 жил" сэдэвт гар зургийн уралдаан, зохион бичлэгийн уралдааныг зарлаад байна. Мөн ахлах ангийн сурагчдад цэрэг-эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх зорилгоор ангийн үйл ажиллагаатай танилцуулж, Орхон аймгийн ЗДТГ-аас зохион байгуулж буй цэрэг-спортын "Дөл" тэмцээнд цэргийн сургалт болон мэргэжлийн зөвлөгөө, зөвлөмжийг өгч, хамтран ажиллаж байна.

Хошууч О.ОТГОНЦЭЦЭГ



ЦЭРГИЙНХЭН АХМАД ДАЙЧИН Ц.ЧИМЭДЦЭРЭНГИЙН НЭРЭМЖИТ ТАНХИМЫГ ТӨРӨЛХ СУМАНД НЬ БАЙГУУЛАВ

Зэвсэгт хүчний 327 дугаар анги

БНМАУ-ын баатар, ЗХУ-ын 4 удаагийн баатар, Маршал Г.К.Жуковын нэрэмжит Зэвсэгт хүчний 327 дугаар ангиас Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тохиолдуулан сурталчилгаа, нөлөөллийн ажлын тасралтгүй зохион байгуулж байна.

Дорнод аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабтай хамтран Халхын голын байлдаанд сайн дураараа мордсон 16 эмэгтэйн алдрыг хойч үедээ бахархан дурсгах, эрэлхэг дайчин эх оронч эмэгтэйчүүдийн нэг ахмад дайчин Ц.Чимэдцэрэнгийн нэрэмжит танхимыг тус аймгийн Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуульд энэ сарын 5-ны өдөр байгууллаа. Танхимын нээлтэд ахмад дайчин Ц.Чимэдцэрэн, түүний үр хүүхэд, орон нутгийн удирдлага, багш, сурагчдын төлөөлөл оролцож, нэгэн өдрийг Халхын голын байлдааны ялалтын үнэ цэнийн тухай хуучилж өнгөрүүлэв.

Баяндун сумын удирдлагууд "Халхын голын байлдаанд манай сумаас 14-18 насны зургаан эмэгтэй мордож байсан бахархам



түүх бий. Өдгөө эр зоригт зургаан эмэгтэйгээс 98 настай Ц.Чимэдцэрэн ахмад дайчин энх тунх байж, урт удаан сайхан насалж байна. Ахмад дайчин маань манай аймгийн тэр дундаа Баяндун сумынхны бахархалт билээ" хэмээн түүний нэрэмжит танхимыг төрөлх суманд байгуулсанд талархал илэрхийлсэн юм. Энэ үеэр иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, цэрэг-эх оронч үзлийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Халхын голын байлдаан болон Чөлөөлөх дайнд хэрэглэгдэж байсан буудлагын зэвсэглэлээр үзэсгэлэн дэлгэж, нутгийн зон олон, хүүхэд залуучуудад

Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, энхийг сахиулах үйлсийг сурталчилсан юм.

Мөн Дорнод аймгийн магадлан итгэмжлэгдсэн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвөөс Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн бие бүрэлдэхүүнд зориулж "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг сургууль дээрээ зохион явуулав.

Сургуулийн захирал Л.Хишигтогтох "Орон нутагт хамтын ажиллагаа бэхэжсэн байгууллагууд гэвэл Зэвсэгт хүчин, Хилийн цэргийн ангиуд болон Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байдаг. Хугацаат албаны дайчдад төрөл бүрийн мэргэжил эзэмшүүлж, нийгэмд бэлтгэгдсэн иргэн бэлтгэхэд манай байгууллагын оролцоо их билээ. Цаашдаа харилцаа, хамтын ажиллагаа улам өргөжүүлэх болно" хэмээгээд багш, суралцагчдын урлагийн тоглолтыг толилуулж, хугацаат цэргийн цэргийн алба хаагчдын дунд "АХА" тэмцээнийг зохиосон юм.

Ахмад Д.ГАНБААТАР

АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ "ДӨЛ-2022" ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙ АВАРГУУД ТОДОРЛОО



Төв аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Төв аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад цэрэг-эх оронч хүмүүжил олгох, эх орон, эх хэл, түүх соёл, уламжлал, эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлэх, тэдэнд бие бялдар сэтгэл зүйн бэлтгэл, тэсвэр хатуужил олгож, эх орноо Батлан хамгаалах бэлтгэл эзэмшүүлэх, монгол цэргийн залгамж халааг бэлтгэх зорилгоор аймгийн аварга шалгаруулах Цэрэг спортын "Дөл-2022" цогцолбор тэмцээнийг Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн байрлалд амжилттай зохион байгууллаа.

Тус тэмцээнд 9 сумын 11 тасгийн 143 сурагчид хурд, хүч, авхаалж самбаа, мэдлэг чадвараа сорин өрсөлдлөө.

БНМАУ-ын баатар Д.Самдангийн нэрэмжит Цэрэг-спортын "Дөл-2022" тэмцээний тэргүүн байрт

шалгарсан Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургуулийн "Залгамж" тасагт аваргын цом, алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, дэд байрт шалгарсан Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн "Оч" тасагт мөнгөн медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, гутгаар байрт шалгарсан "Хүмүүн" цогцолбор



сургуулийн "Элит" тасагт хүрэл медаль, өргөмжлөл мөнгөн шагнал, тусгай байр шалгарсан Алтанбулаг сумын сургуулийн тасагт өргөмжлөл, мөнгөн шагнал тус тус гардууллаа. Мөн шилдэг дасгалжуулагч багшаар "Хүмүүн" цогцолбор сургуулийн биеийн тамирын багш О.Отгонбаяр шалгарсан юм.

